

Петро Матад Лимитед – (цаашид “Петро Матад” эсвэл “Компани” гэх)

Давсан Толгой-1 хайгуулын цооногийн өрөмдлөгө болон өрөмдлөгийн багт ажиллагсад нэмж авсан тухай

ДТ-1 хайгуулын цооногийн өрөмдлөгө

Петро Матад (AIM:MATD) нь 6 сарын 23-ны өдөр Монголын цагаар 02:00 цагт (Английн Стандарт Цагаар 6 дугаар сарын 22-ны 19:00 цагт) ДТ-1 хайгуулын цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэнээ мэдэгдэхэд таатай байна.

ДТ-1 цооногийг босоо чиглэлээр урьдчилан тооцоолсны дагуу ойролцоогоор 1440 метрийн гүнд хүртэл өрөмдөнө. Уг цооногийн өрөмдлөгийн ажлыг Хятадын Ансай Юэйхуа Ойл Тек Лимитед Компанитай (“Ансай Юэйхуа”-Ansaï Yuehua) байгуулсан өрөмдлөгийн гэрээний дагуу гүйцэтгүүлж байна. Өрөмдлөг ойролцоогоор 30 хоног үргэлжилнэ гэж үзэж байгаа бөгөөд өрөмдлөгийн ажил дуусмагц дараагийн мэдээллийг хүргэх болно.

ДТ-1 цооног нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах ХХ талбайд Бүтээгдэхүүн Хуваах Гэрээний дагуу Петро Матадын 2010 онд явуулах өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд өрөмдлөг явуулж эхлэх анхны хайгуулын цооног бөгөөд ХХ талбай нь Компанийн Монгол Улсад эзэмшиж, үйл ажиллагаа явуулж буй хайгуулын гурван талбайн нэг юм

Петро Матадын Багийн шинэ ажилтан

Петро Матад нь төлөвлөгөөт гурван цооногийн хөтөлбөрийн өрөмдлөг дээр ажиллах геологич-петрофизикчээр ноён Франк Уиттеманыг авч ажиллуулхаар болсон. Ноён Уиттеман нь Тамсагийн сав газарт нээлт хийсэн Соко Компанийн анхны гурван цооногууд дээр өрөмдлөгийн ахлах геологич - петрофизикчээр ажиллаж байсан юм.

Тус Компани нь өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажлуудыг гүйцэтгүүлэхээр дэлхий нийтээр газрын тосны талбайн ажил үйлчилгээ үзүүлдэг групп болох Уэдерфорд компанитай гэрээ байгуулж байна. Уэдерфорд Чайна компани нь орчин үеийн хэмжилтийн төхөөрөмжөөр нарийвчилсан бичиглэл хийх бөгөөд петрологи болон геохимийн шинжилгээг АНУ-ын Техас мужийн Хьюстон хотноо байрлах Уэдерфордын лабораторт (Weatherford Laboratories) гүйцэтгэнэ. Калифорнийн Уаандерс Палиноложи Консалтин компани нь уг цооногийн дээжүүдийн биодавхаргазүйн шинжилгээг явуулна.

Нэмэлт мэдээллийг дараахи хүмүүстэй холбоо барьж авна уу:

Петро Матад Лимитед

Даглас Ж. МакГей – Ерөнхий Гүйцэтгэх Захирал

+976-11-331099

Уестхаус Секюритиз Лимитэд

Ричард Бати\Питр Нортон

+44/0/ 20 7601 6100

Банксайд Консалтантс

Симон Ротсчайлд\Оливер Уинтерс\Люис Мэйсн

+44/0/ 20 7367 8888

Редакторуудад зориулсан тайлбар:

Петро Матадын тухай

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол Улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Бүтээгдэхүүн Хуваах гурван Гэрээг (БХГ) дангаараа эзэмшигч байгууллага болно. Үндсэн хөрөнгө нь XX дугаар талбай дээр байгуулсан БХГ бөгөөд уг талбай нь Монголын зүүн хэсэгт орших 14,250 км² газрын тосны талбай юм. Үлдсэн хоёр IV, V талбайнууд нь Монголын Улсын төв хэсэгт орших ба талбайн нийлбэр хэмжээ нь 73,498 км² болно.

Петро Матад нь Айл эф Ман (Isle of Man)- нд бүртгэлтэй бөгөөд 1483V дугаартай компани юм. Бүртгэгдсэн оффисын хаяг Викториа Хаус, Проспект Хилл, Дуглас, Айле ов Ман, АйЭм1 ИКью болно.